



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/03

Мандалговь

Залуучуудын хөгжлийн зөвлөл  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих замаар залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус Залуучуудын хөгжлийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн  
(Б.Үүрийнтуяа)

Гишүүд: Хөрөнгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн  
(Б.Номингэрэл)

Нягтлан бодогч: (Э.Саранзаяа)

2. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гарган батлуулж, хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор албан хаагчдад танилцуулж ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.АДЪЯАСҮРЭН



482117013